



САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ТОГТООЛ

2022 оны 06 сарын 08 өдөр

Дугаар 316

Улаанбаатар хот

┌ Банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх ┐
└ тусгай зөвшөөрөл нэмж олгох тухай ┘

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.3, 6.2.1, 22 дугаар зүйлийн 22.1, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.1, 15 дугаар зүйлийн 15.3.1, Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1, Санхүүгийн зохицуулах хорооны 2016 оны 71 дүгээр тогтоолоор баталсан “Банк бус санхүүгийн үйл ажиллагааны зохицуулалтын журам”-ын 4.4 дэх хэсгийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Наран кредит ББСБ” ХХК-д банк бус санхүүгийн итгэлцлийн үйлчилгээний үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл нэмж олгосугай.

2. Хууль тогтоомжоор хүлээсэн үүргээ биелүүлж, зохих өөрчлөлтийг Улсын бүртгэлийн ерөнхий газарт бүртгүүлж, холбогдох баримт бичгийг Санхүүгийн зохицуулах хороонд ажлын 15 хоногийн дотор ирүүлэхийг “Наран кредит ББСБ” ХХК /Ж.Оюунчимэг/-д үүрэг болгосугай.

3. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж, олон нийтэд мэдээлэхийг Ажлын алба /Т.Жамбаажамц/-нд даалгасугай.

ДАРГА



Д.БАЯРСАЙХАН